

**БАЯЛАГ СҮМБЭР ХК**

# **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**2019 ОНЫ II УЛИРАЛ**



**19**

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Баялаг сүмбэр ХК нь 2019 оны эхний хагас жилд үндсэн үйл ажиллагаагаа эрхлээгүй болно.

Манай компани нь 2019 оны 4 дугаар сарын 29 ний өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж 2018 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах, 3 дугаар сарын 19 ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас дараах байдлаар нэр дэвшүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэв.


Хараат гишүүд: П. Очирхуяг, Б. Отгонбаатар, Ц. Оюунтуяа, Хе Шанжун, Лин юү фэй, Цэнь зу циань

Хараат бус гишүүд: Еэ Монтгомер, Ку чэнь чуань, Цай чин кун

2019 оны 4 сарын 19 ний өдрийн Монголын хөрөнгийн биржийн багцын арилжаагаар тус компанийн хяналтын багцыг буюу 89.6%-ийг Хөхөө агротех ХХК худалдан авснаар компанийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл шинэчлэгдэх шатанд оров. Компанийн тухай хуулийн 57.1 д заасан худалдан авах санал гаргах үүргийн дагуу Баялаг сүмбэр ХК-ийн хувьцааг худалдан авах тендер саналыг хяналтын багц эзэмшигч 2019 оны 4 сарын 29 –ний өдрөөс 5 дугаар сарын 29 ны өдрийг хүртэл зарласан. Энэ хугацаанд хувьцаагаа худалдах санал орж ирээгүй.

Баялаг сүмбэр ХК –ийн 2019 оны 5 сарын 15 ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар ТУЗ-ийн даргаар хараат бус гишүүн Еэ Монтгомер, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Т. Баярмааг, Гүйцэтгэх захирлыг Хе Жинвенг томилов.

## УДИРДЛАГЫН БАГ



Компанийн тухай хуулийн 81.2 дах хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах байдлаар байгуулав.

Аудитын хороо :

Дарга	Yeh Montgomer / хараат бус /
Гишүүд	Tsai Chin-Kun / хараат бус / Ku-Cheng-Chuan / хараат бус / Lin Yu-Fei Б. Отгонбаатар

Цалин урамшуулал хороо :

Дарга	Lin Yu-Fei
Гишүүд	Tsai Chin-Kun / хараат бус / Ku-Cheng-Chuan / хараат бус /

Нэр дэвшүүлэх хороо :

Дарга	Yeh Montgomer / хараат бус /
Гишүүд	Tsai Chin-Kun / хараат бус / He Shanjun

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 61.1.5 дахь хэсэгт заасны дагуу 2019 оны 5 дугаар сарын 15 ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулахаар шийдвэрлэж 7 дугаар сарын 1 ний өдөр хуралдуулав. Уг хурлаар Компанийн оноосон нэрийг “Глобал лайф технологи” болгохоор шийдвэрлэж, компанийн дүрмийг шинэчилсэн найруулга болон үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.

## ИРЭЭДҮЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Цаашид манай компани технологи, худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр бизнес эрхлэх ба дараах чиглэлээр Монголын болон гадаадын тэргүүлэх компаниудтай хамтран ажиллахаар төлөвлөж байгаа юм.

1. Банк, даатгал
2. Байгаль орчныг хамгаалах, тээврийн салбар
3. Үүрэн холбооны салбар
4. Мал аж ахуй газар тариалан
5. Цахилгаан ба Эрчим хүчний салбар

Компанийн хаяг: Хан-Уул дүүрэг, 15 хороо, Мандал хотхон, 42-11 тоот